



ЦДҮС/202001140 ТЕНДЕРТ  
ОРОЛЦОГЧ НАРТ

**ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ  
ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ**  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

Чингисийн өргөн чөлөө 22/1, 3 дугаар хороо,  
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот 17060  
Утас: 7004 2939, Факс: (976) 7004 3287,  
И-мэйл: info@transco.mn, Вэбсайт: www.transco.mn

2020.03.09 № 02/324

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тодруулга хүргүүлэх тухай

Цахилгаан дамжуулах агаарын шугамын утас, арматур, шилэн изолятор нийлүүлэх” тендерийн хувьд дараах тодруулгыг өгч байна. Үүнд:


1. PAC-500 маркийн холболтын хавчаарыг AC-400, PAC-330 маркийн холболтын хавчаарыг AC-240, PAC-120 маркийн холболтын хавчаарыг AC-120 маркийн утсанд тохируулан
2. САСУС-70-1 маркийн тросны холболтын хавчаар
3. 10 кВ оруулгын зажим нь 110/10 кВ 10 мВа хүчний трансформаторын 10 кВ-ын оруулгын холболтод зориулагдсан , 525 А даахуйц, зэсээр хийгдсэн байхаар тус тус нийлүүлнэ.
4. НАС-240-2 (АС-185/43 ба АС-240/39)-ын хувьд ОХУ-ын ГОСТ стандартад тохируулан авахаар тусгасан болно.

ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Б.ДАШДАВАА

172200237



## “НЬЮ ПОВЕР” ХХК

Улаанбаатар – 37 ШХ-186 Сонгино хайрхан  
дүүрэг 4-р хороо Толгойтын /18101/ гудамж  
Утас/Tel/+976 70172283, 99037080, 91916327  
Факс/Fax +976 70172251

И-мэйл: newpowerec@gmail.com

2020 03 03 № 03/19-20

Танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_

## ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-Д

Бид танай байгууллагаас 2020 оны 02 сарын 19-ний өдөр зарласан “Цахилгаан дамжуулах агаарын шугамын утас, арматур, шилэн изолятор” нийлүүлэх ЦДҮС/202001140 тоот тендерт оролцох гэж байгаа бөгөөд дараах тодруулгыг авах хүсэлтэй байна. Иймд дор дурьдсан шугамын арматурын дэлгэрэнгүй үзүүлэлт, зургийг бидэнд хүргүүлнэ үү.

### 1. Холбох хавчаар PAC-120, PAC-240, PAC-400

Тендерийн бичиг баримтанд PAC-500-5A, PAC-330-5A, PAC-120-4A холбох хавчаарын дэлгэрэнгүй үзүүлэлт өгөгдсөн боловч PAC-120, PAC-240, PAC-400 гэсэн маркийн талаар дэлгэрэнгүй үзүүлэлт байхгүй байна. Мөн орос маркаар ийм үзүүлэлттэй хавчаар байхгүй байна.

### 2. Троссны холболтын хавчаар CASUC-70-2

CASUC-70-2 гэсэн маркийн хавчаар байхгүй бөгөөд CASUC-70-1, CASUC-95-1, CASUC-185-1, CASUC-300-1, CASUC-500-1 гэсэн марк байна. Иймд CASUC-70-2 маркийн оронд CASUC-70-1 маркаар нийлүүлэх үү?

### 3. 10кВ-ын оруулгын зажим


Энэ оруулгын зажимны зураг, дэлгэрэнгүй үзүүлэлтийг өгнө үү? Хаана, ямар оролтон дээр ашиглах талаар мэдээлэл өгнө үү?

### 4. Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарын 2,4,18,20,21 дугаарт жишээ нь:

- №20 Таталтын хавчаар PAC-240-2 (AC-185/43, AC240/39 ) 30 ш гэсэн байгаа бөгөөд уг шугамын арматур нь хятад маркаар 2 тусдаа үзүүлэлттэй байгаа тул тус бүрээс нь 15 ш гэж авах уу?

Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР



А.СЭЛЭНГЭ